

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГААС ХӨНГӨЛӨЛТ ҮЗҮҮЛЭХ ЭМИЙН ЖАГСААЛТ,
ХОЛБОГДОХ ЖУРМЫГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ” ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2026 оны 03 дугаар сарын 05

Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөвт багтаан иргэн даатгуулагчдын эрүүл мэндийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эмнэл зүйн хувьд үр дүнтэй, эдийн засгийн хувьд үр ашигтай тусламж үйлчилгээг худалдан авах замаар иргэн даатгуулагчдын тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээ авах эрхийг хангах, улмаар эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлж байгаа билээ. Тус бодлогын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас 2022 оны 07 дугаар сараас эхлэн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн иргэд, даатгуулагчдад эмийн үнийн хөнгөлөлтийг үзүүлсэн. Тогтоолыг хэрэгжүүлэх хугацаанд иргэд эмийн зардлаас үүдсэн санхүүгийн эрсдэлд өртөх, эмийн үнийн дээд хязгаар нь зах зээлийн үнэд дүйцэхгүй байх, цахим жорын баталгаажилт болон хяналт сул байгаагаас үүдсэн санг санаатайгаар хохироох, завших, эмийн үнийн өсөлттэй холбоотойгоор эмийн сангууд хөнгөлөлттэй эмийг олгохоос татгалзах зэрэг асуудлууд үүсч тухайн асуудлыг шийдвэрлэх шаардлага тулгарсан учраас энэхүү тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж, танилцуулгыг хүргүүлж байна.

**Нэг. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолын
хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдал**

Хүснэгт 1. Эмийн үнийн хөнгөлөлтийн хүний тоо, хүртээмж 2021-2025 оноор

Огноо	2021	2022	2023	2024	2025
Хүний тоо	502,858	568,872	645,660	784,828	873,628
Тогтмол эм ууж буй хүний тоо	100,811	116,430	135,640	164,677	176,426
МУ-ын хүн амын тоо	3,409.9	3,457.5	3,504.7	3,544.8	
МУ-ын хүн амд эзлэх хувь	14.75%	16.45%	18.42%	22.14%	
Өмнөх онтой харьцуулахад шинээр нэмэгдсэн хүний тоо		222,803	251,310	319,255	329,030
Шинээр нэмэгдсэн тогтмол эм уудаг хүний тоо		5,095	4,896	5,460	4,365

Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг авч буй даатгуулагчийн тоо нь 2021 оноос хойш тасралтгүй өсөж 5 жилийн хугацаанд 73 хувиар нэмэгдсэн бол зарцуулж буй төсөв нь 3 дахин нэмэгдсэн дүр зурагтай байна. Харин 2025 онд батлагдсан 171 тэрбум төгрөгөөс 40 тэрбум төгрөг нь Төлбөрийг нь төр хариуцах эмэнд зарцуулагдсан ба хөнгөлөлттэй эмэнд 131 тэрбум төгрөгийг төсөвлөсөн болно. Гэвч 2025 онд төсөвлөсөн 131 тэрбум төгрөгөөс 26 тэрбумаар давсан гүйцэтгэлтэй, 2024 онд хөнгөлөлттэй эмийн тусламж үйлчилгээ аваагүй 329 мянга гаруй даатгуулагч 2025 онд тус үйлчилгээг авсан байгаа нь хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний хүртээмж, хэрэгцээ нэмэгдэж байгааг харуулж байна.

График 1. Эмийн үнийн хөнгөлөлтийн батлагдсан төсөв, 2021-2025 оноор





График 2. Эмийн үнийн хөнгөлөлтийн тусламж, үйлчилгээг авсан даатгуулагчийн төрөл, төсвийн зарцуулалтад эзлэх хувь



Эмийн үнийн хөнгөлөлт авч буй нийт даатгуулагчийг шимтгэл төлөлтөөр авч үзвэл 5 даатгуулагч тутмын 2 нь тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн байна. Цаашид лавлагаа

шатлалын тусламж, үйлчилгээнд өндөр хувь эзэлж буй хүүхдийн амьсгалын замын өвчин эмгэгийг эмчлэх хаалга баригчийн тогтолцоог бэхжүүлэхэд хүүхдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 2. Уналт таталтын эсрэг эмийн 0-19 хүртэлх насны хүүхдэд хөнгөлсөн байдал

№	Эмийн нэр	2024 он		2025 он	
		Хүүхдийн тоо	Хөнгөлөлтийн дүн	Хүүхдийн тоо	Хөнгөлөлтийн дүн
1	ВАЛЬПРОНЫ ХҮЧИЛ	121	25,270,995	142	33,910,065
2	ВАЛЬПРОНЫ ХҮЧИЛ (НАТРИЙН ВАЛЬПРОАТ)	1169	451,260,776	1185	485,839,808
3	ГАБАПЕНТИН	42	2,238,090	38	1,612,290
4	ДИАЗЕПАМ	6	27,480	6	67,161
5	ЗОНИСАМИД	34	8,183,683	24	10,720,951
6	КАРБАМАЗЕПИН	1996	318,380,652	2111	418,638,092
7	КЛОНАЗЕПАМ	69	1,465,981	83	2,584,924
8	ЛАКОСАМИД	87	48,495,873	129	84,306,922
9	ЛАМОТРИДЖИН	178	244,855,478	184	331,196,859
10	ЛЕВЕТИРАЦЕТАМ	494	550,768,328	552	748,425,942
11	ОКСКАРБАЗЕПИН	302	299,393,831	342	384,594,004
12	ПРЕГАБАЛИН	11	685,142	23	740,273
13	ТОПИРАМАТ	41	41,763,361	45	74,905,356
14	ФЕНИТОИН	11	390,219	11	507,744
15	ФЕНОБАРБИТАЛ	122	1,399,585	150	1,512,352
Нийт		3606	1,994,579,474	3880	2,579,562,743

Засгийн газрын 2022 оны 33 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2.1-д уналт, таталтын эсрэг эмийг 0-19 хүртэлх насны хүүхдэд 100 хувь хөнгөлөх үүрэг болгон өгсний дагуу уналт, таталтын эсрэг 15 төрлийн эмэнд 2024 онд 0-19 хүртэлх насны 3606 хүүхдэд 1.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн бол 2025 онд 3880 хүүхдэд 2.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн байна. Гэвч МУ-ын эмийн бүртгэлд бүртгэгдээгүй эдгээр уналт, таталтын эсрэг эмийг даатгалын сангаас хөнгөлж байгаа нь хуульд нийцээгүй гэх дүгнэлтийг хяналт, шалгалтын дүгнэлт, тайлан удаа дараа гарч байгаа бөгөөд эдгээрт Сангийн яам, Үндэсний Аудитын газраас хийсэн хяналт, шалгалт багтаж байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмийн үнийн хөнгөлөлт үзүүлж буй тусламж, үйлчилгээний тогтоолын хэрэгжилттэй холбоотой нийгэм, иргэд олон нийт, нийлүүлэгч талууд болон мэргэжлийн холбоодын дунд эрчимтэй яригдаж буй нэг асуудал нь тогтоолоор баталж өгсөн эмийн үнийн дээд хязгаар нь зах зээл дэхь бөөний үнээс доогуур байгаа тул иргэнд шаардлагатай эмийг нь олгох боломжгүй байна, тогтоол бүхэлдээ хэрэгжихгүй байна гэсэн асуудал юм. Энэ асуудлын дагуу хөнгөлөлттэй эмийн жагсаалтад байх эмүүдийн нэхэмжлэлийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

1. ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоол дахь 158 эмийн үнэ нь зах зээлийн үнээс дунджаар 1584 төгрөгөөр их, 217 эмийн үнэ нь зах зээлийн үнээс дунджаар 325 төгрөгөөр бага байна.
2. Тогтоолоор баталсан эмийн үнийн дээд хязгаар нь зах зээлийн үнээс доогуур байгаа тул иргэдэд эм олгохгүй байна, тогтоол хэрэгжихгүй байна гэж байгаа боловч ирж буй нэхэмжлэлийн дүн, хүний тоо жил бүр нэмэгдэж байна, тухайлбал 2023 оны сарын дундаж нэхэмжлэлийн дүн 7.5 тэрбум, 2024 оны дундаж 11.2 тэрбум, 2025 оны дундаж 13.1 тэрбум байна.
3. Тогтоолоор батлагдсан эмийн борлуулалтыг 2025 оноор судлан авч үзвэл олон улсын 161 нэршлийн эмийн 153 нь борлуулагдсан, нийт олон улсын нэршлээр нийт эмийн 69.5 хувь нь буюу 112 эмийн борлуулалт 41.3 хувиар нэмэгдсэн, нэршлийн 21.7 хувь нь буюу 35 эмийн борлуулалт 40.2 хувиар буурсан. Худалдааны 669

нэршлийн эмийн 94.2 хувь нь буюу 629 эм нь борлуулагдсан, нийт худалдааны нэршлийн 57.3 хувь буюу 361 эмийн борлуулалт 73.1 хувиар нэмэгдсэн, 27.8 хувь буюу 175 эмийн борлуулалт 44.9 хувиар буурсан байна. (Хүснэгт 3,4)

4. Эмийн нэхэмжлэлийг үнийн дээд хязгаартай нь холбогдуулан нарийвчлан авч үзвэл эмийн сангаас иргэний халааснаас гарах төлбөрийг үл харгалзан худалдааны нэршлийн бүлэг доторх хамгийн үнэтэй эмийг борлуулж байна, жишээлбэл 2 адилхан эмийн өндөр үнэтэйг нь борлуулсан нэхэмжлэл нь 70 хувийг, 3 адилхан эмийн хамгийн өндөр үнэтэйг нь борлуулсан нэхэмжлэл нь 53 хувийг эзэлж байна. (Хүснэгт 5)

Дээрх дүн шинжилгээний үр дүнгээс үзэхэд дараах дүгнэлтийг хийх боломжтой байна, Үүнд:

1. ЭМДҮЗ-өөс хөнгөлөлттэй эмийн тогтоолыг батлах үед эмийн үнийг гаалийн үнээс нь тооцох боломж нь техникийн хувьд хязгаарлагдмал байсан тул эмийн үнийг зах зээлд нээлттэй байсан үнээр тогтоосон, иймээс зарим эмийн үнэ нь өнөөгийн зах зээлийн үнээс хөөрөгдөлтэй батлагдсан байна. Шинэчилсэн тогтоолын төсөлд эдгээр эмийн үнэ буурах нь зүйтэй.
2. Тогтоолын хэрэгжилт 2025 онд 94.5 хувьтай, эмийн хэрэглээ нь үнийн дээд хязгаараас болж буурсан гэх боловч эсэргээрээ нэмэгдсэн, сар бүрийн нэхэмжлэл нэмэгдсэн, хүний тоо өссөн, тогтмол эм ууж байгаа хүний тоо 330 мянгад хүрсэн байгаа нь хөнгөлөлттэй эмийн хүртээмж нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт 3. Хөнгөлөлттэй эм олголтын 2025 оныг өмнөх онтой харьцуулсан /эмийн ерөнхий нэршлээр/

ОУ нэршил	Эмийн нэршлийн тоо	Эм олголтын хувь	Нэршилд эзлэх хувь
Буурсан	35	-40.27%	21.74%
Хэвэндээ	1		
Нэмэгдсэн	112	41.35%	69.57%
Огт олгоогүй	2		
Шинээр олгосон	3		
Нийт олгосон	153		95.03%
ЭМДҮЗ 11	161		

Хүснэгт 4. Хөнгөлөлттэй эм олголтын 2025 оныг өмнөх онтой харьцуулсан /эмийн худалдааны нэршлээр/

Худалдааны нэршил	Эмийн нэршлийн тоо	Эм олголтын хувь	Нэршилд эзлэх хувь
Буурсан	175	-44.94%	27.82%
Хэвэндээ	2		
Нэмэгдсэн	361	73.12%	57.39%
Огт олгоогүй	9		
Шинээр олгосон	82		
Нийт олгосон	629		94.02%
ЭМДҮЗ 11	669		

3. Гэрээт эмийн сангаас хөнгөлөлттэй эмийг борлуулахдаа иргэний халааснаас төлж байгаа дүнг үл харгалзан нэг бүлэг доторх ижил төрлийн эмээс хамгийн өндөр үнэтэйг нь борлуулж байна. Энэ нь эмийн үнийн дээд хязгаарыг тогтоохдоо гаалийн үнээс нь хувиар тогтоох, түүнээс үүдэн үнэтэй эм борлуулахад өндөр ашиг хийх боломж нээлттэй байгаагаас хамаарч байна. Жишээлбэл, хувиар тогтоох үед гаалийн ширхэгийн үнэ нь 1000 төгрөгийг эмийг эмийн сангаас борлуулахад 409.5 төгрөгийн нэмэгдэлтэй байх бол 1500 төгрөгийн ширхэгийн үнэтэй эмийн эцсийн


хэрэглэгчид борлуулах үеийн нэмэгдэл нь 614.25 төгрөг байна. Иймд сангийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, иргэний халааснаас харах зардлыг бууруулахад нэг төрлийн эмийг борлуулахад нэмэгдэх мөнгөн дүн нь ижил эсвэл ойролцоо байх томъёоллыг боловсруулах шаардлага байна.

Хүснэгт 5. Нэг ижил нэршил, тун, хэлбэр бүхий эмийг үнээс хамааран олгож байгаа байдал

Бүлэг дэхь эмийн тоо	Үнийн эрэмбэ	Эзлэх хувь		Бүлэг дэхь эмийн тоо	Үнийн эрэмбэ	Эзлэх хувь
2	1	70%		6	1	38%
2	2	30%		6	2	14%
3	1	53%		6	3	32%
3	2	32%		6	4	6%
3	3	13%		6	5	6%
4	1	41%		6	6	2%
4	2	14%		7	1	28%
4	3	24%		7	2	26%
4	4	8%		7	3	13%
5	1	2%		7	4	7%
5	2	47%		7	5	17%
5	3	15%		7	6	5%
5	4	23%		7	7	1%
5	5	2%				

Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний чанар, эмнэлгийн тусламж үйлчилгээний уяалдаа холбоо, төсвийн үр ашигтай зарцуулалтын хүрээнд хийсэн гол дүн шинжилгээний нэг нь зүрх судасны тогтолцооны эмгэгийн улмаас тогтмол эм уух шаардлагатай иргэдийн дунд хийсэн судалгаа байна. Энэхүү дүн шинжилгээний зорилго нь зүрх судасны эмгэгийн эмийг тогтмол, хөнгөлөлттэйгөөр хэрэглэж байгаа иргэд болон эмчилгээний тасалдалтай иргэд, эм уудаггүй иргэдийг харьцуулан тухайн оношоороо болон хүндрэлийн оношоор дээд шатлалын эрүүл мэндийн байгууллагад тусламж үйлчилгээг авч байгаа эсэхийг тогтоох байв. Тухайлбал, зүрхний артерийн даралт ихсэх өвчтэй иргэнийг тухайн оношоор эсвэл түүний хүндрэлийн оношоор 2 болон 3 дахь шатлалын эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх, өндөр өртөгт оношилгоо шинжилгээ, мэс заслын тусламж үйлчилгээ авсан эсэх, түүний харилцаа хамаарлыг эмчилгээний тогтмол байдалтай нь хамааруулан судлав. Дүн шинжилгээний үр дүнгээс товч дурьдвал хөнгөлөлттэй эмийг тогтмол хэрэглэдэггүй хүмүүс тухайн оношоор лавлагаа шатлалын эмнэлэгт тухайн оношоор тусламж, үйлчилгээ авснаар түүнд сангаас олгож байгаа мөнгөн дүн нь тогтмол эм хэрэглэдэг хүмүүстэй харьцуулахад 3.7-4.2 дахин их, хүндрэлийн оношийн хүрээнд 6.1-7.3 дахин их байна (График 3). Үүнээс үзэхэд зүрх судасны тогтолцооны үед шаардлагатай эмийг хөнгөлөлттэйгөөр тогтмол уух нь төсвийн үр ашигтай зарцуулалтыг 3.7-7.3 дахин нэмэгдүүлэх боломжтой байна.

График 3



Хоёр. Одоогийн хэрэгжиж буй тогтоолд орох өөрчлөлт, оролцогч талуудад нөлөөлөх байдал

2.1. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний зохицуулалт, журамд орж буй бодлогын өөрчлөлт, оролцогч талуудад үзүүлэх нөлөө

Эрүүл мэндийн бүх нийтийн хамралт (ЭМБНХ)-ыг анхан шатанд бэхжүүлэх, түүнд хүрэхэд даатгуулагч нь орон зай, цаг хугацаанаас үл хамааран хөнгөлөлттэй эмийг санхүүгийн эрсдэлгүйгээр авдаг байх нь нэн шаардлагатай байна. Даатгуулагчийг энэхүү боломжоор хангаж өгөхийн тулд тухайн тусламжийг хүртээмжтэй, тэгш байдлыг хангасан, санхүүгийн хамгаалалт үүсгэсэн байх үндсэн 3 үзүүлэлтийг сайжруулах зорилгоор энэхүү шинэчилсэн тогтоолын төсөлд тусгаж өгсөн, Үүнд:

- Хөнгөлөлттэй эмийн хүртээмжийг сайжруулахад эхлээд нийслэл, орон нутгийн алслагдсан байршилд гэрээт эмийн сантай байх, эмийн санд тухайн бүс нутгийн иргэдийн өвчлөл, тоо, хэрэгцээнд нийцсэн эмийн нэр төрөл, түүний нөөц хангалттай байх шаардлагатай байна. Мөн даатгуулагчийн жоронд бичигдсэн бүх эмийг нэг дор нэг цаг хугацаанд олгож байх нь хүртээмжийг хэмжих чухал үзүүлэлт болж байна. Жишээлбэл, жоронд бичигдсэн 3 төрлийн эмийг даатгуулагчид нэг цаг хугацаанд хүндрэл чирэгдэлгүй хөнгөлөлттэй үнээр олгосон тохиолдолд тодорхой хэмжээний нэмэгдлийг коэффициентээр тооцож урамшуулдаг байх зохицуулалтыг төсвийн орон зайг харгалзан үзэж байж хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

- Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг үзүүлж буй нийлүүлэгч талд тэгш байдлыг нэмэгдүүлэх, иргэн талд мөн хүртээмжийг сайжруулах зорилгоор хоёр болон гурав дахь шатанд хэрэгжүүлж буй “бүсийн коэффициент”-ийг нэвтрүүлэхээр энэхүү тогтоолын төсөлд тусгасан. Хөнгөлөлттэй эмийн үнийн дээд хязгаарыг шинэчилсэн томъёоллоор тооцохдоо Улаанбаатар хотоос орон нутагт тээвэрлэх зардлыг шингээн тооцоогүй тул энэ

зохицуулалтыг эмийн сангийн байршлаас хамааран санхүүжилтийн дүн дээр коэффициентоор тооцох бодлогыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

- Анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагч тусламж, үйлчилгээг авахад эрүүл мэндмээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлд орохгүй байх нь бүх нийтийн эрүүл мэндийн хамралтын чухал үзүүлэлт болдог. Харин өнөөдрийн байдлаар даатгуулагч анхан шатны тусламж, үйлчилгээний чухал бүрэлдэхүүн хэсэг болох хөнгөлөлттэй эмийг авахад 39 хувийг халааснаасаа төлж байгаа бөгөөд энэ нь 101.4 тэрбум төгрөг байна. Иймд тогтмол эм уух шаардлагатай архаг өвчтэй даатгуулагчдад санхүүгийн хамгаалалт үүсгэх зорилгоор цалингийн дундаж хэмжээ, өрхийн дундаж орлогын хэмжээнээс нь хамааран тухайн жилийн эмийн хэрэглээнд “хамтын төлбөрийн тааз”-ыг тогтоож өгсөн. Тухайлбал, хамтын төлбөрийн таазад хүрсэн тохиолдолд төсвийн жилийг дуусах хүртэл хөнгөлөлттэй эмийн хүрээнд даатгуулагчийн төлж буй хамтын төлбөрийг тодорхой хэмжээгээр бууруулах эсвэл бүрэн даах эсэхийг төсвийн орон зайг харгалзан үзэж хэрэгжүүлэхээр төлөвлөв. Энэ зохицуулалт нь дэлхийн бусад орнуудад өргөн хэрэглэгддэг тэгш байдлыг хангасан бодлогын тохируулагч бөгөөд түүний тод жишээ нь Дани улсад хэрэгдэгддэг хэрэглээнээс хамаарсан хамтын төлбөрийн тааз тогтоох аргачлал юм. Энэхүү тохируулагч нь тэтгэврийн иргэд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд болон тогтмол эм уух шаардлагатай архаг өвчтэй иргэдэд анхан шатны тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй байлгахад чиглэсэн бодлогын хэрэглүүр юм.

- Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээг оновчтой болгох, хяналтыг сайжруулах зорилгоор эмчийг жор бичих үед нь эмнэлзүйн үндэслэлийг шаарддаг байх, иргэний мэдээллийг хурууны хээгээр эсвэл И-Монголиад бүртгэлтэй утасны дугаарыг ашиглан баталгаажуулдаг байх зэрэг хөгжүүлэлтийг цахим системийн хүрээнд хийх шинэчлэл болгон тогтоолын төсөлд тусгасан.

2.2.Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орж буй өөрчлөлт, оролцогч талуудад үзүүлэх нөлөө

Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг шинэчлэн боловсруулахдаа батлагдсан аргачлалын дагуу тодорхой өвчнийг шалгуурын дагуу сонгох, сонгогдсон өвчний үед хэрэглэхийг зөвлөсөн эмүүдийг олон улсын эмнэлзүйн удирдамж болон Монгол Улсын эмийн бүртгэлийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мэдээллийг ашигласан. Хөнгөлөлт үзүүлж буй нийт 669 эмээс шаардлага хангаж буй 395 эмийг нь шинэчилсэн тогтоолын төсөлд тусгасан, 274 эм нь хасагдсан. Үүнд, 206 нь бүртгэлгүй, 68 нь бүртгэлтэй хэдий ч зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад байхгүй, жоргүй олгох, гаалийн үнийн мэдээлэл нь олдоогүй эсвэл олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөөгүй эмүүд байх тул тусгагдаагүй байна. Тухайлбал 2025 оны 01-10 дугаар сарын байдлаар 14.9 тэрбум төгрөгийн хөнгөлөлт олгосон Урсодооксихолийн хүчил эм нь Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/408 дугаар тушаалаар баталсан жагсаалтад “жоргүй” гэж заасан тул, мөн хугацаанд 4.4 тэрбум төгрөгийн хөнгөлөлт олгосон Цитиколин эмийг олон улсын эмнэлзүйн удирдамжид зөвлөөгүй¹, судалгааны шатандаа байгаа эм гэсэн тул энэхүү 2 эмийг шинэчилсэн тогтоолын төсөлд тусгаагүй. Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/197 дугаар тушаалаар баталсан Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад жороор олгодог эсэх нь тодорхойгүй буюу тэмдэглэгээ байхгүй эмүүдийн талаар Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас тодруулахад 2025 оны 01/733 дугаартай албан бичгээр “сэлгээ эм гэдэг нь эдийн засаг болон бусад нөхцлүүдээс хамааран оношилгоо эмчилгээнд нэмэлтээр

¹ <https://www.uptodate.com/contents/treatment-of-vascular-cognitive-impairment-and-dementia>,
<https://www.uptodate.com/contents/nonarteritic-anterior-ischemic-optic-neuropathy-prognosis-and-treatment#H14>

сэлгэн сонгох боломжтой зайлшгүй шаардлагатай эмүүд болно” гэсэн тул тухайн эмүүдийг тогтоолын төсөлд тусгав.

Нэхэмжлэлийн тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд тогтоолын төсөлд тусгаагүй Урсодеоксихолийн хүчил, Цитиколлин эмийг 2025 оны 01-10 дугаар сарын байдлаар давхардаагүй тоогоор 203 мянган хүн хөнгөлөлттэй авч хэрэглэсэн байх ба тухайн эмийг хэрэглэдэг иргэдийн эрх ашиг тодорхой хэмжээгээр хөндөгдөх эрсдэлтэй байна. Мөн Засгийн газрын 2022 оны 33 дугаар хурлын тэмдэглэлд үүрэг болгосны дагуу уналт, таталт өвчний үед хэрэглэгдэх Монгол Улсад бүртгэлгүй 42 эмийг түр зохицуулалт хийн хөнгөлөлттэй эмийн жагсаалтад оруулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолд оруулсан байсанг хасч, Засгийн газрын хурлын тэмдэглэл болон Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/407 дугаар тушаалын дагуу “Төрөөс төлбөрийг нь хариуцах зарим өвчин эмгэг, түүний эмийн жагсаалт”-д оруулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар батлуулсан. Иймд, дээрх эмүүдийг хэрэглэдэг иргэдийн эрх ашгийн хамгаалах, хүндрэл чирэгдлийг бууруулахын тулд зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг боловсронгуй болгох, Монгол Улсад бүртгэлгүй уналт, таталтын эсрэг эмүүдийг бүртгэлжүүлэх, эрүүл мэндийн байгууллага болон эмийн санд нөөц бүрдүүлэлтийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Одоогийн хэрэгжиж буй тогтоолоос шаардлага хангаж буй 395 эмээс 20 нь Новартис хөтөлбөрийн эм тул үнийн өөрчлөлт оруулаагүй, бусад эмийн үнийн дээд хязгаарыг Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн үнийн мэдээлэлд үндэслэн томьёоллын дагуу шинэчлэн тооцсон. Шинээр боловсруулсан томьёоллын дагуу тооцоход нийт 375 эмийн 1 ширхэгийн үнэ нь 479 төгрөгөөр буюу 2786-с 2307 болж буурсан, тухайлан авч үзвэл 158 эмийн үнэ 1 ширхэг нь дунджаар 1584 төгрөгөөр буюу 3678-с 2093 төгрөг болж буурсан, 217 эмийн үнэ 1 ширхэг нь 2137-с 2463 төгрөг болж дунджаар 325 төгрөгөөр нэмэгдсэн, 20 эмийн үнэ өөрчлөгдөөгүй байна. Үнэ буурсан 158 эмийн үнэ нь анхнаасаа үнийн хөөрөгдөлтэй батлагдсан нь тухайн үед буюу 2022 онд эмийн үнийн дээд хязгаарыг тооцох мэдээллийн эх үүсвэр дутмаг, тодорхой томьёололгүй байсантай холбоотой. Харин тухайн эмүүдийн үнийн дээд хязгаарыг шинээр боловсруулсан томьёоллын дагуу гаалийн үнийн мэдээллээс нь тооцож үзэхэд буурч байна. Үнэ өөрчлөгдөөгүй 20 эм нь Засгийн газраас хэрэгжүүлж буй Новартис хөтөлбөрийн хүрээнд урьдчилан тогтоосон үнэтэй эмүүд байна.

Шинэчилсэн тогтоолын төсөлд ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолд байх шалгуур хангаж буй ерөнхий нэршлийн 122 эмийн хүрээнд Монгол Улсад шинээр бүртгэгдсэн худалдааны нэршлийн эмүүдийг нэмж тусгасан, мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгээс хассан 143 өвчнийг амбулаториор эмчлэхэд шаардлагатай ерөнхий нэршлийн 14, худалдааны нэршлийн 46 эм, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс ирүүлсэн амбулаторийн өвчлөлийн тохиолдлын тоон мэдээллийг шалгуурын дагуу үнэлж түүнд хэрэглэх ерөнхий нэршлийн 3, худалдааны нэршлийн 30 эмийг тогтоолын төсөлд шинээр нэмж тусгасан бөгөөд нийт 142 ерөнхий нэршлийн 790 эм болсон. Тогтоолын шинэчлэлийн хүрээнд жагсаалтад орж буй өөрчлөлтийг танилцуулгын хавсралтад дэлгэрэнгүй тусгав.

Гурав. Шинэчилсэн тогтоолын төсөлд тусгасан бодлогын шинэчлэл, өөрчлөлт болон шийдэл

Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад орсон бодлогын шинэчлэл, өөрчлөлт

2.1. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 11 дүгээр тогтоолыг батлах үед Монгол Улсын хэмжээнд эмийн үнийн баталгаатай мэдээлэл байхгүй, загварын хувьд нэг ширхэг эмийн үнийг тооцоолох боломжгүй байсан тул тухайн үеийн зах зээлийн үнийг шууд ашиглаж байсан. Харин энэхүү тогтоолын төсөлд Гаалийн ерөнхий газар, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас манай байгууллагад албан байдлаар ирүүлсэн 2022 оноос 2025 оны 12 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаарх үнийн мэдээллийг үндэслэл болгон ашигласан. Ингэснээр одоогийн хэрэгжиж буй тогтоолд байх эмүүдийн үнийн мэдээллийг гаалийн үнээс эхлэн инфляци, долларын ханштай уяалдуулан бодитой тогтоох, зах зээлд хэт үнийн хөөрөгдөлтэй байгаа эмийн үнийг холбогдох томьёоллын дагуу тооцон бууруулах ач холбогдолтой байна. Үнийн хөөрөгдөлтэй байгаа эмийн үнийг бодитой тогтоох нь нөгөө талдаа иргэдийн халааснаас гарч буй эмийн зардлыг бууруулах боломжийг ЭМДЕГ-т бүрдүүлж өгч байна.

2.2. Энэхүү тогтоолын төсөлд эмийн үнийн дээд хязгаарын томьёоллыг боловсруулахдаа Зүүн өмнөд Азийн орнууд, эмийн хатуу зохицуулалттай Европын орнууд болон Номхон далайн баруун эргийн бүсийн орнуудын туршлага, судалгаанд үндэслэж дараах томьёоллын дагуу үе шаттайгаар тооцсон болно. Үүнд:

1. Эм бүрийн гаалийн үнийг Гаалийн ерөнхий газраас ирүүлсэн 2022-2025.12.31 өдрийн байдлаарх үнийн мэдээлэл болон Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас ирүүлсэн эмийн бүртгэлийн дугаарын мэдээллийг ашиглан тооцсон.
2. Эмийн ерөнхий нэршил, тун, хэлбэр, хэрэглээний савлагаа болон чанарын үзүүлэлтийг оруулах зорилгоор ДЭМБ-ын эмийн хатуу зохицуулалттай орноос импортлогдсон эсэх мэдээллийг ашиглан бүлэг үүсгэсэн.

Жишээ:

Бүлэг 1: Азитромицин + 250мг + шахмал + нэг удаа хэрэглэх савлагаатай + Герман улсаас импортлогдсон

Бүлэг 2: Азитромицин + 250мг + шахмал + нэг удаа хэрэглэх савлагаатай + Энэтхэг улсаас импортлогдсон.

3. Дээрх бүлгийн дагуу бүлгийн жигнэсэн дундаж үнийг тооцож, бүлгийн жигнэсэн дундаж үнээс бөөний болон жижиглэнгийн нэмэгдэх тогтмол мөнгөн дүнг тооцсон. Тооцохдоо бөөний нэмэгдлийг 15%, жижиглэнгийн нэмэгдлийг бөөний нэмэгдэл орсон дүнгээс 20%-иар тооцсон.
4. Эм тус бүрийн гаалийн үнээс Гаалийн татвар 5%, бөөний болон жижиглэнгийн нэмэгдэл орсон дүнгээс НӨАТ 10%-ийг тооцож үнийн дээд хязгаарыг тооцсон.
5. Нэг эх үүсвэрийн 18 эмийн үнийн дээд хязгаарыг тооцохдоо Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газраас ирүүлсэн бөөний үнэ дээр жижиглэнгийн нэмэгдэл мөнгөн дүнг нэмж үнийн дээд хязгаарыг тооцсон. Тухайн эмүүдийн зардлыг урьдчилан эрүүл мэндийн даатгалын сангаас төлсөн, мөн бөөний нэмэгдлийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газраас тендер зарлах замаар урьдчилан тогтоож өгсөн.
6. Новартис хөтөлбөрийн 20 эмийн үнэд өөрчлөлт оруулаагүй.

Эмийн үнийн дээд хязгаарыг тооцох зах зээлд тогтсон аргачлал

Эмийн олон улсын нэршил /ЭОУН/	Эмийн хэлбэр	Савлалтын тун	Худалдааны нэр	Гаалийн үнэ	Гаалийн татвар 5%	Бөөний нэмэгдэл 30%	Жижиглэнгийн нэмэгдэл 30%	НӨАТ 10%	Хувиар нэмэгдүүлсэн үнийн дээд хязгаар
Азитромицин	шахмал/капсул	500мг	Корзит	766	38	241	314	150	1,496

Азитромицин	шахмал/капсул	500мг	Зитролин	926	46	292	379	181	1,808
Азитромицин	шахмал/капсул	500мг	Азитромицин	1,738	87	548	712	339	3,393
Азитромицин	шахмал/капсул	500мг	Азитромицин дигидрат	1,209	60	381	495	236	2,361

Шинээр боловсруулсан аргачлал

Эмийн олон улсын нэршил /ЭОУН/	Эмийн хэлбэр	Савлалтын тун	Худалдааны нэр	Гаалийн үнэ	Бүлгийн жигнэсэн дундаж үнэ	Гаалийн татвар 5%	Бөөний нэмэгдэл	Жижиглэнгийн нэмэгдэл	НӨАТ 10%	Шинэ үнийн дээд хязгаар
Азитромицин	шахмал/капсул	500мг	Корзит	766	807	38	242	315	150	1,497
Азитромицин	шахмал/капсул	500мг	Зитролин	926	807	46	242	315	168	1,682
Азитромицин	шахмал/капсул	500мг	Азитромицин	1,738	807	87	242	315	262	2,620
Азитромицин	шахмал/капсул	500мг	Азитромицин дигидрат	1,209	807	60	242	315	201	2,009

2.4. Эрүүл мэндийн даатгалын сангаас эмэнд үзүүлэх хөнгөлөлтийн хэмжээ буюу сангаас төлөх хэмжээг тогтоохдоо эмээс үүдсэн халаасны зардлыг бууруулах, санхүүгийн хамгаалалт үүсгэх үндсэн зарчмыг баримталсан. Үүнд:

1. Амбулаториор эмчлэх боломжтой өвчний эмнэлгийн тусламжийн тохиолдлыг бууруулах, анхан шатыг бэхжүүлэх зорилгоор насан туршид эм уух заалттай артерын даралт ихсэлт болон түүний хүндрэлийг агуулсан зүрх судасны өвчний үед хэрэглэхийг зөвлөсөн эмүүдийг сонгон авч бүлэг доторх худалдааны нэршлийн эмүүдийн хамгийн хямд үнэтэй эмийн үнийн дүнгийн 70 хувиар нь хөнгөлсөн.

2. Хүүхдийн амьсгалын замын өвчин түүний хүндрэл болох уушгины хатгаа зэрэг өвчнийг амбулаториор эмчлэхэд өрх гэрээс эмэнд төлж буй зардал нь лавлагаа шатлалын эмнэлэгт үзүүлэн эмчилгээ хийлгэх зардлаас өндөр байгаа нь тухайн өвчний үед хэрэглэхийг зөвлөсөн эмүүдийн хамтын төлбөрийг бууруулах, боломжтой бол халааснаас мөнгө төлөхгүй байх бодлогын алхамыг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэдгийг харуулж байна. Иймд тухайн өвчний үед хэрэглэгдэх эмүүдийг бүлэг доторх хамгийн хямд үнэтэй эмийн үнийн дүнгийн 70 хувиар нь хөнгөлсөн.

3. Бусад өвчний үед хэрэглэгдэх эмүүдийг худалдааны нэршлийн бүлэг дэхь хамгийн бага үнэтэй эмийн үнийн дүнгийн 50 хувиар хөнгөлсөн.

Энэхүү шинээр нэвтрүүлж буй хөнгөлөлтийн хувийг тогтоох аргачлалын онцлог нь иргэний халааснаасаа төлөх зардал нь иргэний мэдээлэл, сонголтоос ихээхэн хамаарах ба иргэн ухаалаг сонголт хийж чадвал санхүүгийн дарамтгүйгээр өөрт тулгараад буй эрүүл мэндийн хэрэгцээ, асуудлаа шийдвэрлэх боломжтой байдаг.

Гурав. Тогтоолын төсөл хэрэгжсэнээр хүрэх үр дүн

“Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлт үзүүлэх эмийн жагсаалт, холбогдох журмыг шинэчлэн батлах тухай” тогтоолыг шинэчлэн батлуулсанаар дараах үр дүнд хүрнэ гэж үзэж байна. Үүнд:

1. Эмийн үнийн дээд хязгаарыг шинэчлэн тогтоосноор гэрээ бүхий эмийн сангаас даатгуулагчид хөнгөлөлттэй эмийн цахим жорыг хүндрэл чирэгдэлгүй олгох;
2. Эрүүл мэндийн байгууллага, эмчээс онош ахиулсан жор бичилт буурах, эмийн сангаас хуурамч, харьяаллын бус жор олголт буурах
3. Хөнгөлөлттэй эмийн тусламж, үйлчилгээний иргэний хяналт сайжрах, иргэний РД-ыг ашиглан хуурамч жор бичих, олгох тохиолдол буурах
4. Иргэн нь орон зай, цаг хугацаанаас үл хамааран хөнгөлөлттэй эмийн чанартай тусламж, үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй, санхүүгийн дарамтгүйгээр авах тохиолдол нэмэгдэх
5. Хөнгөлөлттэй эмийн хүрээнд батлагдсан төсвийн зарцуулалтын үр ашигтай байдал дээшлэх

Жич: Хөнгөлөлттэй эмийн жагсаалтад багтах боломжгүй эмийн жагсаалтыг хавсаргав

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

